

АГУУЛГА


I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
I.1 Төслийн талаарх мэдээлэл.....	2
I.2 Уурхайн ажиллах горим	3
I.3 Техник технологи.....	3
I.4 Баяжуулалтын технологи.....	4
I.4.1 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт	4
I.5 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг	7
II. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ	9
II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд.....	9
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	14
III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	15
III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	15
III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	15
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	16
IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	21
IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах.....	21
IV.4 Тэр бум мод үндэсний хөтөлбөр.....	24
IV.5 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	24
IV.6 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	24
IV.7 Хатуу хог хаягдлын менежмент	25
IV.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	26
IV.9 Байгалийн гамшгаас үүсэж болзошгүй ослын менежментийн төлөвлөгөө	30
V. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	30

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төслийн талаарх мэдээлэл

Төслийн байршил: “Өлзийт-Ухаа” төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 290 орчим км-т, Дорноговь аймгийн төв Сайншанд хотоос баруун хойш 167 км-т, Даланжаргалан сумын төвөөс баруун хойш 30 гаруй км, Говь-Сүмбэр аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 59 км зайд оршино.

MV-021469 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Төмрийн хүдрийн орд нь засаг захиргааны хуваариар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-49-114 хавтгайд 123.84 га талбайг эзлэн оршино.



Зураг № 1 Төслийн талбайн байршил

Хүснэгт№ 1 Талбайн газар зүйн солбицол

Талбайн булангийн цэгүүд	Өргөрөг	Уртраг
1	108° 49' 17.62"	46° 1' 57.33"
2	108° 49' 17.62"	46° 1' 23.65"
3	108° 48' 40.61"	46° 1' 23.65"
4	108° 48' 40.61"	46° 1' 40.66"
5	108° 48' 15.62"	46° 1' 40.66"
6	108° 48' 15.62"	46° 1' 23.65"
7	108° 48' 9.62"	46° 1' 23.65"
8	108° 48' 9.62"	46° 1' 57.33"

Төсөл хэрэгжүүлэгч: “Хас металл” ХХК нь Монгол улсын 9011511015 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо МН товер, 13 давхарт, 1304 тоот. Утас:88011111.

1.2 Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй 353 хоног ажиллана. Үлдсэн 12 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар тооцов. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана. Ил уурхайн ажиллах ээлжийн зохион байгуулалтыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт№ 2 Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горим	Үзүүлэлт	
Хуанлийн хоног	365	өдөр
Баяр ёслол	9	өдөр
Цаг агаарын хүнд нөхцөл тооцсон хоног	3	өдөр
Жилийн ажлын өдөр	353	өдөр
Ээлжийн үргэлжлэх хугацаа	12	цаг
Хоногт ажиллах ээлжийн тоо	2	ээлж
Ээлжийн цаг ашиглалт		
Ажлын наряд авах	15	мин
Хоолны цаг	60	мин
Ээлж хүлээлгэн өгөх	20	мин
Бусад	20	мин
Ээлжин дэх сул зогсолт	115	мин
Ээлжийн үргэлжлэх хугацаа	12.0	цаг
Ээлжийн цэвэр ажиллах цаг	10.1	цаг
Ээлжийн цаг ашиглалт	84%	
Жилд ажиллах цэвэр ажлын цаг	7,119	цаг/жил

1.3 Техник технологи

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдээс гадна зам талбай засах, түлш цэнэглэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүднээс дараах туслах тоног төхөөрөмжүүд уурхайд ажиллана. Дараах хүснэгтэд уурхайд ажиллах усны машины техникийн үзүүлэлтийг харууллаа.

Хүснэгт№ 3 Sinotruck-Water tank маркийн усны машины техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Нэгж	Water tank
Усны савны багтаамж	литр	12000
Хөдөлгүүрийн чадал	мх	150-250
Түлшний хэлбэр		Дизель
Хамгийн их хурд	км/цаг	90



Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй ажиллагааг хангах мөн зарим нь шатахуун түгээгүүрээс шууд цэнэглэх боломжгүй тул зайлшгүй түлшний машин ажиллана. Уурхайд 30 тн багтаамжтай дараах түлшний машиныг ашиглахаар тооцов.

Хүснэгт№ 4 Sinotruck-Petrol tanker маркийн түлшний машины техникийн үзүүлэлт


Үзүүлэлт	Нэгж	Petrol tanker
Багтаамж	тн	30

Хөдөлгүүрийн чадал	мх	251-350	
Түлшний хэлбэр		Дизель	
Жин	кг	11360	
Дугуйн томьёо		6x4	

Уурхай дээр аж ахуйн бараа материал, сэлбэг, үйлчилгээний бараа материалуудыг ачих буулгах зэрэг уурхай туслах ажилд зориулж өргөгч машин 1 ширхэгийг ажиллуулна.

Уулын мастер, уулын инженерүүдийн ажлын өдөр тутмын хэрэгцээнд зориулж Ниссан патрол-Пикап маркийн суудлын тэргийг авч ажиллуулна.

Хүснэгт№ 5 Nissan patrol маркийн Pickup суудлын машины техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Нэгж	Nissan Pickup	
Он		2016	
Хөдөлгүүрийн чадал	мх	136	
Түлшний хэлбэр		Газ/петрол	
Хамгийн их явах хурд	км/цаг	170	
Түлшний хэрэглээ	литр/100км	12.7-13.1	

I.4 Баяжуулалтын технологи

Ордын төмрийн хүдэрт технологийн туршилтыг “Монголын алт” ХХК-ийн технологийн судалгааны төвд 177 кг дээжид гүйцэтгэсэн байна.

Уурхайд баяжуулах үйлдвэр байгуулж төмрийн хүдрийг 2 шатны хуурай цэврэлгээтэй соронзон баяжуулалтаар баяжуулах бөгөөд 56.22%-ийн гарцтай, 54.73%-ийн төмрийн агуулгатай, 72.34%-ийн металл авалттай баяжмал гарган авна.

Баяжуулах үйлдвэрт 1-р жилд 67.3 мян.тн, 2-р жилд 87.5 мян.тн, харин 3-р жилд 94.6 мян.тн хүдэр баяжуулж, нийт 140.2 мян.тн 54.73%-ийн агуулгатай баяжмалыг гаргана.

I.4.1 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт

Бутлуурын сонголт, тооцоо

Хацарт бутлуурын сонголт, тооцоо

Хацарт бутлуурт өгөх тэжээлийн хэмжээ: $Q = 45.9$ тн/цаг. Хацарт бутлуурын сонголт, тооцоог бутлуурын бүтээмжид тулгуурлан гүйцэтгэв.

$$Q_0 = K_1 * K_2 * K_3 * K_4 * Q_s = 1.1 * 0.95 * 1.15 * 1.05 * 59.5 = 75.1$$

Энд: Q_0 - төслийн тооцооны хүчин чадал, тн/цаг

K_1 - хүдрийн бутлагдах чадвараас хамаарсан коэффициент: 1.0

K_2 - хүдрийн нягтаас хамаарсан коэффициент: 0.95

K_3 - анхдагч хүдрийн ширхэглэлээс хамаарсан коэффициент: 1.1

K_4 - хүдрийн чийглэгээс хамаарсан коэффициент: 1.05

Q_s - стандарт нөхцөлд задгай циклд ажиллах үеийн хүчин чадал, тн/цаг

$$Q_s = q_0 * e = 0.85 * 70 = 59.5$$

q_0 - бутлуурын нэгж хугацаанд хүдэр гаргах амсрын өргөнөөс хамаарсан бутлагдах хүдрийн хэмжээ, тн/(мм*цаг)

e - бутлуурын хүдэр гаргах амсрын өргөн, мм

Хэрэглэгдэх бутлуурын тоо: $n = Q/Q_0 = 45.9/75.1 = 0.66 \approx 1$ ширхэг

Тооцоогоор PE-600x900 маркийн конусан бутлуур 1 ширхэгийг сонгов.

Хүснэгт№ 6 Хацарт бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		PE-900*600
2	Хүдэр орох амсарын хэмжээ	мм	900*600
3	Хамгийн том ширхэглэлийн хэмжээ	мм	500
4	Хүчин чадал	тн/цаг	70-120
5	Гарах амсарын хэмжээ, мм	мм	65-160
6	Цахилгаан зарцуулалт	кВт	75
7	Нийт жин	тн	29
8	Хэрэглэгдэх тоо	ш	1



Конусан бутлуурын сонголт, тооцоо

1-р шатны конусан бутлуурт өгөх тэжээлийн хэмжээ: $Q = 52.2$ тн/цаг. Конусан бутлуурын сонголт, тооцоог бутлуурын бүтээмжид тулгуурлан гүйцэтгэв.

$$Q_0 = K_1 * K_2 * K_3 * K_4 * Q_s = 1.1 * 0.95 * 1.15 * 1.05 * 85.5 = 107.9 \text{ тн/цаг}$$

Энд: Q_0 - төслийн тооцооны хүчин чадал, тн/цаг

K_1 - хүдрийн бутлагдах чадвараас хамаарсан коэффициент: 1.1

K_2 - хүдрийн нягтаас хамаарсан коэффициент: 0.95

K_3 - анхдагч хүдрийн ширхэглэлээс хамаарсан коэффициент: 1.15

K_4 - хүдрийн чийглэгээс хамаарсан коэффициент: 1.05

Q_s - стандарт нөхцөлд задгай циклд ажиллах үеийн хүчин чадал, тн/цаг

$$Q_s = q_0 * e = 2.85 * 25 = 85.5$$

q_0 - бутлуурын нэгж хугацаанд хүдэр гаргах амсрын өргөнөөс хамаарсан бутлагдах хүдрийн хэмжээ, тн/(мм*цаг)

e - бутлуурын хүдэр гаргах амсрын өргөн, мм

Хэрэглэгдэх бутлуурын тоо: $n = Q/Q_0 = 52.2/107.9 = 0.5 \approx 1$ ширхэг

Тооцоогоор SP200B маркийн конусан бутлуур 1 ширхэгийг сонгов.

Хүснэгт№ 7 Конусан бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		SP200B
2	Хамгийн том мөхлөгийн хэмжээ	мм	95
3	Хүчин чадал	тн/цаг	95-115
4	Гарах амсарын хэмжээ	мм	13-35
5	Цахилгаан зарцуулалт	кВт	185
6	Нийт жин	тн	24.7
7	Хэрэглэгдэх тоо	ш	1



2-р шатны конусан бутлуурт өгөх тэжээлийн хэмжээ: $Q = 34.8$ тн/цаг. Конусан бутлуурын сонголт, тооцоог бутлуурын бүтээмжид тулгуурлан гүйцэтгэв.

$$Q_0 = K_1 * K_2 * K_3 * K_4 * Q_s = 1.1 * 0.95 * 1.15 * 1.05 * 33.25 = 41.95 \text{ тн/цаг}$$

Энд: Q_0 - төслийн тооцооны хүчин чадал, тн/цаг

K_1 - хүдрийн бутлагдах чадвараас хамаарсан коэффициент: 1.1

K_2 - хүдрийн нягтаас хамаарсан коэффициент: 0.95

K_3 - анхдагч хүдрийн ширхэглэлээс хамаарсан коэффициент: 1.15

K_4 - хүдрийн чийглэгээс хамаарсан коэффициент: 1.05

Q_s - стандарт нөхцөлд задгай циклд ажиллах үеийн хүчин чадал, тн/цаг

$$Q_s = q_0 * e = 6.65 * 6 = 33.25$$

q_0 - бутлуурын нэгж хугацаанд хүдэр гаргах амсрын өргөнөөс хамаарсан бутлагдах хүдрийн хэмжээ, тн/(мм*цаг)

e - бутлуурын хүдэр гаргах амсрын өргөн, мм

Хэрэглэгдэх бутлуурын тоо: $n = Q/Q_0 = 34.8/41.95 = 0.83 \approx 1$ ширхэг.

Тооцоогоор РҮН330 маркийн конусан бутлуур 1 ширхгийг сонгов

Хүснэгт№ 8 Конусан бутлуурын техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Нэгж	Тоон утга
1	Тоног төхөөрөмжийн марк		РҮН330
2	Хамгийн том мөхлөгийн хэмжээ	мм	35-50
3	Хүчин чадал	тн/цаг	30-95
4	Гарах амсарын хэмжээ	мм	3-13
5	Цахилгаан зарцуулалт	кВт	220
6	Нийт жин	тн	13.5
7	Хэрэглэгдэх тоо	ш	1



Шигшүүрийн сонголт, тооцоо

1-р шатны хяналтын шигшүүрт өгөх тэжээлийн хэмжээ: $Q = 69.6$ тн/цаг

$$Q_0 = \varphi * F * V * \delta_0 * K_1 * K_2 * K_3 * K_4 * K_5 * K_6 * K_7 * K_8 = 227 \text{ тн/цаг}$$

Энд: Q_0 - чичиргээт шигшүүрийн бүтээмж, тн/(ш*цаг)

φ - чичиргээт шигшүүрийн ашигтай талбайн коэффициент: 0.9

F - чичиргээт шигшүүрийн торны талбай, m^2 : 4.5

V - шигшүүрийн нэгж талбайд шигших хүдрийн хэмжээ, $m/(m^2*цаг)$: 15.46

δ_0 - материалын нягт, $тн/м^3$: 3.78

K_1 - хүдрийн дунд, нарийн ширхэглэлтэй мөхлөгөөс хамаарсан коэффициент: 0.95

K_2 - хүдрийн ширхэглэлийн мөхлөгөөс хамаарсан коэффициент: 1.0

K_3 - шигшилтийн бүтээмжээс хамаарсан коэффициент: 1.2

K_4 - хүдрийн төрөл болон хэлбэрээс хамаарсан коэффициент: 0.9

K_5 - материалын чийглэгээс хамаарсан коэффициент: 1.0

K_6 - шигших аргаас хамаарсан коэффициент: 1.1

K_7 - шигшүүрийн хөдөлгөөнөөс хамаарсан коэффициент: 0.85


K_8 - шигшүүрийн тор болон нүхний хэлбэрээс хамаарсан коэффициент: 1.0

$$F_z = Q/Q_0 = 69.6/227.0 = 0.3 \approx 1 \text{ ширхэг}$$

Тооцоогоор УАК1530 маркийн чичиргээт шигшүүр 1 ширхгийг сонгов.

Хүснэгт№ 9 Чичиргээт шигшүүрийн техникийн үзүүлэлт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоон утга
---	--------------------	-----------

1	Тоног төхөөрөмжийн марк	YAK1530	
2	Шигшүүрийн торны тоо, ширхэг	1	
3	Шигшүүрийн налуу, °	17.5	
4	Торны хэмжээ, м²	4.5	
5	Шигших давтамж, эрг/мин	970	
6	Хүчин чадал, тн/цаг	60-210	
7	Цахилгаан зарцуулалт, кВт	11	
8	Шигшүүрийн хэмжээ, мм	1500*3000	
9	Далайц, мм	6-8	
10	Нийт жин, тн	8.7	
11	Хэрэглэгдэх тоо, шир	1	

2-р шатны хяналтын шигшүүрт өгөх тэжээлийн хэмжээ: $Q=104.4$ тн/цаг

$$Q_0 = \varphi * F * V * \delta_0 * K_1 * K_2 * K_3 * K_4 * K_5 * K_6 * K_7 * K_8 = 340 \text{ тн/цаг.}$$

Энд: Q_0 - чичиргээт шигшүүрийн бүтээмж, тн/(ш*цаг)

φ - чичиргээт шигшүүрийн ашигтай талбайн коэффициент: 0.9

F - чичиргээт шигшүүрийн торны талбай, м²: 18

V - шигшүүрийн нэгж талбайд шигших хүдрийн хэмжээ, м/(м²*цаг): 5.8

δ_0 - материалын нягт, тн/м³: 3.78

K_1 - хүдрийн дунд, нарийн ширхэглэлтэй мөхлөгөөс хамаарсан коэффициент: 0.95

K_2 - хүдрийн ширхэглэлийн мөхлөгөөс хамаарсан коэффициент: 1.0

K_3 - шигшилтийн бүтээмжээс хамаарсан коэффициент: 1.2

K_4 - хүдрийн төрөл болон хэлбэрээс хамаарсан коэффициент: 0.9

K_5 - материалын чийглэгээс хамаарсан коэффициент: 1.0

K_6 - шигших аргаас хамаарсан коэффициент: 1.1

K_7 - шигшүүрийн хөдөлгөөнөөс хамаарсан коэффициент: 0.85

K_8 - шигшүүрийн тор болон нүхний хэлбэрээс хамаарсан коэффициент: 1.0


$$F_z = Q/Q_0 = 104.4/340.0 = 0.3 \approx 1 \text{ ширхэг}$$

Тооцоогоор 2LF3060 маркийн чичиргээт шигшүүр 1 ширхгийг сонгов.

I.5 Инженер хангамж, дэд бүтэц, бусад хэсэг

Цахилгаан хангамж: Үйлдвэрлэлийн үндсэн цахилгаан хэрэглэгч нь уурхайн тосгоноос гадна ил уурхайн гэрэлтүүлэг, ус хангамжийн хэсэг, хүдрийн агуулах, пүүний хэсэг, тэсрэх материалын агуулах, хяналтын байр зэрэг байх болно. Мөн түүнээс гадна ашиглалтын туршид засварын газар, шатахуун түгээгүүр зэрэг хэрэглэгчид цахилгаан эрчим хүч хэрэглэнэ.

Усан хангамж: “Хас металл” ХХК нь төслийн хугацаанд ашиглагдах усыг “Мөнгөн хас шонхор” ХХК-тай байгуулсан 22/02 тоот ус ашиглах гэрээний дагуу гүний худгаас хангана. “Мөнгөн хас шонхор” ХХК-ийн гүний худаг нь 7л/с-ийн ундрагатай. Худгийн байршлыг доор үзүүлэв.



Зураг № 2 Гүний худгийн байршил

Уурхайн бүтээгдэхүүн олборлолт, баяжуулалтанд ямар нэгэн ус ашиглахгүй. Төмрийн хүдрийг 2 шатны хуурай соронзон сеператорын аргаар баяжуулна.

Унд ахуйн ус: Ил уурхайн нийт ажилчдын 60-70% нь уурхай дээр ажиллах бөгөөд үлдсэн хүмүүс нь ээлжийн амралттай байна. Ингэснээр уурхай дээр ашиглалтын жил бүр дэх ажиллах хүчний тооноос хамаарч, нийт 47 хүн ажиллана. Уурхай дээр шаардлагатай унд-ахуйн усны тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт№ 10 Унд ахуйн усны хэрэглээ

Норм, л/хоног	Хүний тоо, ш	Цэвэр усны хэрэглээ	
		м3/хоног	мян.м3/жил
50 ¹	47	2.35	0.0024

Зам талбайн усалгаа: Олборлолтын явцад 8000 м² талбайг салхи ихтэй үед услаж байх шаарлагатай. Ногоон байгууламжийн усалгааг тус тушаалын 13-р хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д 1м² талбайд 4 л, “Технологийн хэрэглээ буюу зам, талбайн усалгаа”-д 1м² талбайд 2 л гэсэн нормыг тус тус баримталж ус хэрэглээний тооцоог хийж дараах хүснэгтэд үзүүлэв.

¹ БОНХАЖСайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн ” А/301-р тушаалын 12-р хавсралт “Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системд холбогдоогүй орон сууц”

Хүснэгт№ 11 Зам талбайн усалгаа

№	Ашиглалтын жил	Зам талбай м ² /Нэмэгдэх дүнгээр/	Усалгаа норм, л	Нийт, л	Мян.м ³	Жилд мян.м ³ /16 удаа/
1	1-р жил	2500	2	5000	0.005	0.08
2	2-р жил	4800	2	9600	0.0096	0.1536
3	3-р жил	8000	2	16000	0.016	0.256
4	4-р жил	8000	2	16000	0.016	0.256
Нийт дүн				16000	0.016	0.4896

Хүснэгт№ 12 Уурхайн нийт усны хэрэглээ

№	Төслийн жил	Хотхоны хэрэглээ, мян.м ³ /жил	Зам талбайн усалгаа мян.м ³ /жил	Уурхайн нийт хэрэглээнд
				мян.м ³ /жил
1	1-р жил	0.0024	0.08	0.0824
2	2-р жил	0.0024	0.1536	0.156
3	3-р жил	0.0024	0.256	0.2584
4	4-р жил	0.0024	0.256	0.2584
Нийт			0.4896	0.4968

II. БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Физик газарзүй: “Өлзийт-ухаа” төмрийн хүдрийн ордын уурхай нь физик газарзүйн мужлалаараа Монголын дорнод талын их мужийн халхын дундад ба Дарьгангын мужид хамрагдана. Даланжаргалан сум нь Сайншандын суурьт болон давхаргат өндөрлөг тал, хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл- цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлийн дэд муж, Зүүнбаяны суурьт болон давхаргат өндөрлөг тал хотгор, сул сэргэж хэлбэршсэн үлдмэл- цулдам уул, бэлэрхэг уул бүхий цөлийн дэд мужид хамаарагдана. Гадаргын өндөршилийн хувьд тус сумын нутаг нь элэгдэл эвдрэлд ихээхэн өртсөн дундаж, нам үлдэц уулс бүхий ухаа-гүвээт, толгодот, нугачаат тал бүхий гадаргатай. Районы гадарга нь толгодорхог уулархаг төрөлд хамаарах ба “Өлзийт-Ухаа” төмрийн хүдрийн орд нь далайн түвшнээс дээш 1225-1300 м өндөрт өргөгдсөн мөлгөрдүү оройтой тэгш талархаг гадаргуутай. Талбайн 20%-ийг уул толгод, 80%-ийг тал хээр эзэлнэ.

Уур амьсгал: Дорноговь аймаг нь Монголын эрс тэс уур амьсгалтай, дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Хамгийн их халуун /300 ба түүнээс дээш/ 7 ба 8-р сард үргэлжлэх ба дундаар 20-25 хэм, хамгийн их хүйтрэлт 1-р сард болдог. Өвлийн дундаж хэм -20-15 байна. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноос байх ба хавар, намрын улиралд хүчтэй шороон шуурга элбэг тохиолддог. Жилд дунджаар 150-205 мм тунадас унах ба 7 ба 8-р сард зонхилно. Хур тунадас их унасан үед хуурай сайруудаар үерийн ус урсдаг.

II.1 Цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд


Дорноговь аймгийн зүүн хэсгээр жилийн дундаж агаарын температур 5.5⁰С, нутгийн хойд хэсгээр харьцангуй хүйтэн 0.3⁰С, бусад нутгаар 3.5-3.7⁰С дулаан байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур нутгийн хойд талаар 18.7⁰С, зүүн хэсгээр 21.3⁰С, төв болон өмнөд хэсгээр 23.1-24.0⁰С дулаан байна. Үнэмлэхүй хамгийн их температур Сайншанд,

Замын -Үүд орчмоор 41.5-41.6 °С, Мандахад 39.6°С, Чойрт 38.6°С хүрч халсан бөгөөд энэхүү үнэмлэхүй их утгууд нь 1999 оны 7-р сарын 26,28, 2000 оны 7-р сарын 13-нд тус тус ажиглагдсан байна.

Ер нь манай орны ихэнх нутгаар 1999-2000 оны зуны хэт халалтын үеэр үнэмлэхүй их температурын захын утгууд эвдэрсэн билээ. Тус нутгаар 36.3-40.2°С-ийн үнэмлэхүй хамгийн их температур 5 %-ийн хангамжтай буюу 20 жилд нэг удаа тохиолдоно.



Зураг № 3 Даланжаргалан сумын агаарын температурын норм



Зураг № 4 Даланжаргалан сумын агаарын үнэмлэхүй температур

Агаарын температур: Дорноговь аймгийн зүүн хэсгээр жилийн дундаж агаарын температур 5.5°С, нутгийн хойд хэсгээр харьцангуй хүйтэн 0.3°С, бусад нутгаар 3.5-3.7°С дулаан байна. Жилийн хамгийн дулаан 7-р сарын дундаж агаарын температур нутгийн хойд талаар 18.7°С, зүүн хэсгээр 21.3°С, төв болон өмнөд хэсгээр 23.1-24.0°С дулаан байна. Үнэмлэхүй хамгийн их температур Сайншанд, Замын -Үүд орчмоор 41.5-41.6°С, Мандахад 39.6°С, Чойрт 38.6°С хүрч

халсан бөгөөд энэхүү үнэмлэхүй их утгууд нь 1999 оны 7-р сарын 26,28, 2000 оны 7-р сарын 13-нд тус тус ажиглагдсан байна. Ер нь манай орны ихэнх нутгаар 1999-2000 оны зуны хэт халалтын үеэр үнэмлэхүй их температурын захын утгууд эвдэрсэн билээ. Тус нутгаар 36.3-40.2⁰C-ийн үнэмлэхүй хамгийн их температур 5 %-ийн хангамжтай буюу 20 жилд нэг удаа тохиолдоно.

Жилийн хамгийн хүйтэн 1-р сарын агаарын дундаж температур тус аймагт -15.3⁰C -20.7⁰C-ын хооронд хэлбэлзэнэ. Үнэмлэхүй хамгийн бага температур нутгийн төв болон өмнөд хэсгээр -41.4-41.5⁰C, бусад хэсгээр -34.5-37.0⁰C хүрч хүйтэрсэн байна. Аймгийн хэмжээнд үнэмлэхүй хамгийн бага температур Замын-Үүд орчмоор 1957 оны 1-р сарын 12-нд ажиглагдаж -41.5⁰C хүрч хүйтэрсэн байна. Сарын дундаж агаарын температурын дундаж квадрат хазайлт өвлийн саруудад 2.0-3.4⁰C, зуны саруудад 1.3-1.5⁰C тус тус байна.

Хүснэгт№ 13 Агаарын температурын үзүүлэлтүүд

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жилийн дундаж
Агаарын дундаж температур	-16.8	-16.4	3.2	5.2	11.4	18.9	21.2	17.3	15.8	2.4	-8.4	16.1	3.14
Үнэмлэхүй их температур	-1.3	3.2	14.1	23.2	32.9	32.4	34	32.9	30.6	23.8	12.8	-3.5	19.59
Үнэмлэхүй бага температур	-29.1	-33.6	-16	-7.9	-3.1	4.5	10.9	7.3	1.2	-12	-27.5	-33.1	-11.53

Хөрсөн бүрхэвч: Монгол орны хөрс газарзүйн муж-лалаар төв Азийн их мужийн хүрэн хөрсний муж, дундад халхын тойрогт хамаарагдана. Нутгийн хойд хэсгээр хүрэн хөрс, уулархаг хэсгээр чулуурхаг, сайргархаг хар хүрэн хөрс тархсан. Нутгийн өмнөд хэсгээр ердийн хүрэн хужирлаг мараалаг хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Энэ бүс нутагт мөн Хуурай хээрийн ба цөлжүү хээрийн хөрс ихэчлэн тархсан бөгөөд үүнд: Даланжаргалан сумын хувьд нутгийн зүүн болон төвийн хэсгээр нунтаг карбонатлаг цайвар хүрэн хөрс тархсан. Харин нутгийн өмнө болон зүүн урд хэсгээр нунтаг карбонатлаг хүрэн хөрс, хойд болон баруун хэсгээр нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, тус тус зонхилон тархсан байна. Хөрсний 0-50 см гүний чийгшлийн нийлбэр нь хаврын улиралд 5 мм, харин намар цагт 15 мм хүрдэг байна.

Амьтны аймаг: Монгол орны амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүний үүсэл, хөгжилт, тархалтад тус орны хотгор гүдгэр, уур амьсгалын нөхцөл, ургамал нөмрөг ихээхэн нөлөө үзүүлжээ. Амьтдын тэжээл ургамлын аймгийн бүрэлдэхүүнтэй нягт холбоотой учраас байгалийн бүс бүслүүрийг дагаж нэг бүс, бүслүүрт тодорхой амьтад зонхилж байхад зарим төрлийн амьтад шилжин амьдрах нь ч бий. Тус оронд хөхтний 136 зүйл, шувууны 426 зүйл, загасны 75 зүйл, хоёр нутагтны 8 зүйл, мөлхөгчийн 22 зүйл, хавч хэлбэртний 210 зүйл, шавжийн 10000 гаруй зүйл, зөөлөн биетний 26 зүйл, хорхойн 456 зүйл, эгэл биетэн 24 зүйл тэмдэглэгдсэн ажээ (Санжмятав.3, 2007).

Аймгийн нутаг дэвсгэр нь монгол орны био-газарзүйн мужлалаар төв халхын хээр, дорнод говийн зааг нутагт хамаарагдана. Нутгийн дийлэнх хэсгийг

хуурай хээр эзлэх тул амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүнд хээрийн амьтад зонхилдог. Түүнчлэн говь цөлийн амьтад цөөнгүй бий.

Эдгээр зүйлийн амьтдаас Даланжаргалан сумын нутгаар:

•Аргаль, угалз, мануул, зурам, хулан, цагаан зээр, үнэг, хярс, дорго, дэлдэн зараа, дагуурын зараа, атаахай, чичүүл, алагдаахай, үхэр огодой,

Хөхтний бүлгэмдлийн амьтад:

•Монгол огодой, дагуур зурам, орог зусаг, дагуурын сохор номин, хэргэлзэй оготно, үлийн цагаан оготно, монгол чигчүүл, хярс, цагаан үен, цагаан зээр гэх мэт

Шувуу:

•Сойр, хур, тас, сар бүргэд, ууль, сохор элээ, боролзой болжмор, монгол болжмор, хон хэрээ, улаан хушуут, гэх мэт 19 нэр төрлийн жигүүртэн байдаг.

Зэрлэг туурайтан:

•Мануул, дорго, үнэг, чоно, хярс зэрэг амьтад амьдарна.

Монголын Улаан номонд орсон аргаль, янгир, ирвэс, хар сүүлт, эрээн хүрнэ, хадны суусар, шилүүс, мануул, цооховдой, өөхөн сүүлт болон таван хуруут атигдаахай, зурам, цагаан зээр зэрэг амьтадтай.

Ургамлын нөмрөг: Энд жинхэнэ хуурай хээрийн ландшафт зонхилохын зэрэгцээ говь цөлийн нөлөөгөөр ургамлан бүрхэвчийн үндсэн бүрэлдэхүүнүүд цөлөрхөг хээрийн элементүүд нэвтэрч, ургамлын бүрхэвч мэдэгдэхүйц сийрэг болсон байна. Агь-үетэн-харганат хээр голлох суурийг эзлэх боловч монгол өвст, таана-монгол өвст хээр бас тохиолдоно. Ууландаа боржино цохио хад асагны завсар хооронд болон ам хөндий, сайр, гуу жалганы ёроолоор таана, хөмүүл, шарилж, хазаар өвс, сайрын хялгана, крыловын хялгана, гялгар дэрс, сарвуун сонгино, харлаг өмхий өвс зэрэг нэг ба олон наст ургамал ургана.

Мөн зээргэнэ, тарваган харгана, алтан харгана ургана түүнчлэн аймгийн хэмжээнд 47 төрлийн эмийн болон хүнсний ургамал ургадгаас санал болгож буй нутагт хөмүүл, мангир, гоньд, агь, ямаан бут, алтан харгана, ганга өвс, царван элбэг ургана.

Улаанбаатараас Сайншанд орох замын дагуу баянтал, сүмбэр, малах талуудаар хялгана хазаар өвс, хялганат, дэрст цайрам хэрлэн голын эрэг хүртэл үргэлжилнэ. Сайншандын уудам районд Говьсүмбэр аймгийн Чойр хотоос урагших монгол өвст, таанат бүлгэмдэл зонхилж, хонхор хотгор газраар сийрэг улаан бударгана, шар бударгана, хэрс тааралдана. Дорноговь аймгийн ургамалжилт ургамал газар зүйн 2 тойрогт хамаарагдаж байна.

Монгол орны нутаг дэвсгэр хойноосоо урагш чиглэлд өргөргийн өөрчлөлттэй холбоотойгоор хэд хэдэн босоо бүслүүрийг үүсгэдэг онцлогтой. Энэ онцлогийн дагуу ургамалжилтын доорх бүс бүслүүрт хувааж үзсэн байдаг. Үүнд:

- 1.Өндөр уулын (тагийн) бүслүүр
- 2.Уулт тайгын бүслүүр
- 3.Уулын хээрийн ойн (тагийн доод) бүслүүр
- 4.Хээрийн бүс
- 5.Цөлөрхөг хээрийн бүс
- 6.Цөлийн бүс

Төсөл хэрэгжих талбай нь ургамалжилтын дээрх бүс бүслүүрийн хээрийн бүсэд хамаарагдана.

Дэд бүтэц, нийгэм эдийн засгийн байдал: Дорноговь аймаг нь Монгол улсын аймаг юм. 1931 онд байгуулагдсан. 14 сум, 64 багатай. 68606 хүнамтай (2017 оны эцсээр) бөгөөд олон хүн ам огцом өсөж байна. Аймгийн төв Сайншанд нь улсын нийслэл Улаанбаатар хотоос 450 км-т оршдог. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил үалган оршдог. БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Хойд, урд хоср гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг.

Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 61 хувь нь оршин сууж байна. Тус аймагт 2017 оны эцсийн байдлаар 20844 өрхөд 68606 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 1,5 хүн ногдож байна. Тэдний 61 хувь нь хот тосгонд, 15,2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Хүн амын 48,7 хувь нь эрэгтэйчүүд, 51,3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нэг өрхөд дунджаар 3,4 хүн ноогддог. Нийт 19,7 мянган ажиллагсад байгаа нь ажил эрхэлж байгаа нэг хүнд 2,6 хүн ноогдож байна.

Хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр тус аймаг улсын дунджаас дээгүүр байна. Нийт өрхийн 15,2 хувь, хүн амын 19,6 хувь нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой амьдарч байна.

Дорноговь аймгийн Даланжаргалан сум нь ардын хувьсгалын ялалтын дараахан буюу 1924 онд нутгийн захиргаадыг байгуулж эхлэх тэрхүү цаг дор БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдийн Ү тогтоолоор Хан-хэнтий уулын хошуунд ДАЛАНЖАРГАЛАН нэртэйгээр байгуулсан түүхтэй. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харъяалагдаж 1959 онд одоогийн төвлөрч байгаа “Цомог” хэмээх газарт суурьшжээ.Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-овоо гэсэн 5 багийн нийт 833 өрхөд 2625 хүн амьдардаг.

Суманд бүртгэлтэй ажилгүй 20 иргэн байна. Нийт ажилгүй иргэдийн 75,0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 1 хувийг дээд, 5 хувийг тусгай дунд, 61 хувийг бүрэн дунд, 26 хувийг бүрэн бус дунд, 7 хувийг бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна.

Сумын хэмжээнд 107607 толгой малтайгаас 578 тэмээ, 5635 адуу, 3528 үхэр, 51862 хонь, 46004 ямаа байна. Сумын хэмжээгээр нийт цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 26000 толгой мал тоологдсон нь нийт малын 24,2 хувь байна. 312 малчин өрх, 103 мал бүхий өрх байгаа нь сумын нийт өрхийн 49,8 хувийг эзэлж байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ
Хүснэгт №. 14 Төслөөс үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Орчин	Сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	Эрсдэлийн зэрэглэл
Газрын хэвлий	Уурхайн барилга байгууламжаар эвдрэлд орно	Төслийн талбайд	Их
Агаар	Олон хүний хөдөлгөөн, машин механизмын яндангаас гарах утаанаас болж агаар бохирдоно.	Төслийн талбай, түүний орчим	Дунд
Хөрсөн бүрхэвч	Хөрсөн бүрхэвч бүр мөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ургамлын бүрхэвч	Талбайн ургамал бүрмөсөн устаж, төслийн бусад талбайн хөрс элэгдэл эвдрэлд өртөнө.	Төслийн талбайд	Их
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Тоосжилт, ХАБЭА-н дүрэм журмыг сайн хангаагүй тохиолдолд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлнө.	Төслийн талбайд	Бага
Ус	Газрын доорх усны түвшинд нөлөөлж улмаар нөөц багасах, хуурайших, голын усны түвшин багасах, шатахуун, шатах тослох материалын асгарагчаас ус бохирдож болзошгүй	Төслийн талбай орчим	Бага

III.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Машин механизмын яндангаас гарах утаа болон ахуйн хог хаягдал, олон хүний хөдөлгөөнөөс болж агаарын чанарт нөлөө үзүүлнэ.

Мөн уурхайн олборлолтын үед тоос дэгдэж, агаарын чанарт сөрөг нөлөөлөл үүснэ.

III.2 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлын нөмрөг шороон дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлын нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг, бүрхэц арви багсана.
- Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэх
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй

III.3 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс

хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

Зэрлэг амьтан уурхайн дуу чимээнээс зугтан дайжиж, ан амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх зэрэг үр дагавар гарч болзошгүй тул булах осолгүй ажлыг байнга хийнэ.

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ

Төлөвлөгөөний танилцуулга: Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулав.

Хүснэгт № 15 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал


№	Зардлын утга	Нэг жилийн зардал мян.төг
1	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	5370.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал	3400.0
3	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	800.0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1580.0
5	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15350 ²
	Нийт	11150.0

IV.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

² Нөхөн сэргээлтийн зардлыг үйл ажиллагааны төсвөөс шийдвэрлэнэ.

Хүснэгт№ 14 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	
Агаар орчин								
1	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, бутлалт овоолго зэрэг газар шорооны ажил Ажилчдын суурин болон уурхайн олборлолтын үеийн газар шорооны ажил Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.	Төсөлд ашиглагдах 4 техник тоног төхөөрөмжид	4*40.0 =160.0	160.0	Олборлолтод гарахын өмнө	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн ерөнхий шаардлага)	
		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавина /TWCAT002,TWCAT0061 маркийн шүүлтүүр/	Төсөлд ашиглагдах 4 техник тоног төхөөрөмжид	4 * 40,0 = 160.0	160.0	Олборлолтод гарахын өмнө	-MNS4225:2011 (Агаарын чанар, Ерөнхий танилцуулга) -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам	
			Олборлолтын ажлын үед газар шорооны ажлыг аль болохоор бага хэмжээтэй хязгаартай хийнэ	Уулын ажлын үед		-	Төслийн бүх үе шатанд	
			Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлана	Уурхайн зам болон орон нутгийн зам		-	Төслийн бүх үе шатанд	
			Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын	Уурхайн зам		Үйл ажиллагааны зардалд тусгана.	Төслийн бүх үе шатанд	

	орчны агаар бохирдох	гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засна (олборлолтын ажлаас өмнө)					суурьшсан хэсгүүдэд) -Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 -Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 MNS5010-2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
		Тоосжилтыг дарах зорилгоор авто зам, уурхайн карьерын мөргөцөг, шимт хөрсний овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр	Уурхайн зам, карьерын мөргөцөг, овоолго			Төсөл хэрэгжих хугацаанд	
2	Уурхайлалт, олборлолт, техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны улмаас дуу чимээ ихээр үүсэж ажилчид болон нутгийн иргэд дуу чимээний бохирдолд орох	Зам харгуйг засварлан сайжруулж тэмдэгжүүлнэ	Уурхайн болон орон нутгийн замд	150.0	150.0	Төсөл хэрэгжих хугацаанд	-MNS ISO 226:2003 дуу чимээ-хэвийн норм-түвшний хэмжээ
		Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэнэ.	Уурхай дотор		-	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	
		Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмын ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгана. Уг багажийг хэрэв БОТЛ-аас түрээсэлбэл түрээсийн зардал нэг удаа 25000 төг	Лицензийн талбайд	25.0 төг *2 цэгт = 50.0	50.0	Жилд нэг удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ.	
Усны нөөц, чанар							
3	Гадаргын усыг авч ашигласнаар голын урсцын горим алдагдах,	ШТМ-ын агуулахын орчмыг хатуу хучилттай болгоно.	ШТМ-ын агуулах болон түүний орчим	550.0	550.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль

	усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Уурхайн олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглана.	Лицензийн талбайд	700.0	700.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	-ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ
Хөрс, ургамлын бүрхэвч							
4	Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Уурхайн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлнэ.	Төсөл хэрэгжих талбай болон түүний орчим	Үйл ажиллагааны зардалд тусгана.		Төслийн эхэнд	-Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авах. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгална.	Төсөл хэрэгжих талбайд				
		Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна.	Орон нутагтай хамтран гэрээгээр зайлуулна.	Үйл ажиллагааны зардал тусгана.	Тухай бүрд		
		ШТМ-ын хадгалалтад хяналт тавина.	ШТМ-ын агуулахад			Уулын ажил	

Амьтны аймаг							
5	Ухсан нүх, карьерт амьтад орж үрэгдэх, дуу чимээний нөлөөллөөс үргэж дайжих	Уурхайн бүсэд хамгаалалтын хашаа барих, шувууны үүр барьж өгөх	Лицензийн талбайн ойр орчим болон орон нутагт	600.0	600.0	Төслийн эхэнд	Амьтны тухай хууль
Хөндлөнгийн хяналт							
6	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг 2 жил тутамд хийлгэнэ.	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	3000.0	3000.0	2023 онд	
Нийт зардал				5370.0	5370.0		

IV.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Олборлолт ажил явагдсан нутаг дэвсгэрийн физик газарзүйн нөхцөл, геоморфологийн тогтоц, нутаг дэвсгэрийн болон технологийн онцлогоос хамаарч нөхөн сэргээлтийн ажлыг цаашид бэлчээрийн зориулалтаар ашиглах шаардлагыг хангах хэмжээнд хүртэл гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлтэд ашиглалтын явцад эвдрэлд орох талбайнуудыг аль болох сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулан засах зорилт тавигдана. Уурхайн хотхоныг тойроод навчит ургамалаар нөхөн сэргээлт хийнэ. 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаар 3.2 га талбайд нөхөн сэргээлт хийнэ. Үүнээс уурхайн хотхоны арын хэсгээр 2 га, олон наст ургамал 0.7 га, тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 0,5 га талбайд тус тус нөхөн сэргээлт хийнэ.

Хүснэгт№ 17 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө


№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Тоо, ш	Модны үнэ, мян.төг
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал					
1	Хайлаас	га	1	1500	8 250 000
2	Шар хуайс	га	1	1500	6 000 000
Олон нас , кг					
1	Согоовор	га	0.3	20	500 000
2	Шар хуайс	га	0.4	24	600 000
Нийт		га	2.7		15 350 000 мян.төг

IV.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт төслийн талбайд ойр орших газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Дүйцүүлэн хамгаалах ажлуудыг гүйцэтгэх талбайн хэмжээний хувьд дараах байдлаар сонгосон болно. Үүнд:

- 1-р жилд төслийн талбайгаас зүүн зүгт 3.8 км-д орших 13997 м²



Дүйцүүлэн хамгаалах ажил хийх талбайн сонголт

№	Дүйцүүлэн хамгаалах хийх талбай	Хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1-р жил	13997 м ²	Эвдэрч эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Даланжаргалан сумын нутагт	1 м ² талбайд 3500 төгрөг	48 989.5 ³	276 059. 0 ⁵	Жил бүр	Байгаль орчин аялал жуулчлалын яам, Дорноговь аймгийн Байгаль орчны газраас гаргасан зөвлөмжийн дагуу
2-р жил	2051 м ²				7 178.5			
3-р жил	60082 м ²				210 287.0			
4-р жил	2744 м ²				9 604.0			
Нийт	78874.0 м² 4							

Хүснэгт№ 18 Осол эрсдэлийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
Галын аюул, гамшиг, осол аюул	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458 : 2014 стандартад заасан химийн бодисын агуулахын холбогдох бүх шаардлагыг барилгын зураг төсөл, тогтмол үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж стандартыг мөрдөж ажиллах	Барилгын зураг төсөл ба үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд			Үйл ажиллагааны эхний жилд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Гал гарах үед анхааруулгын самбар объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566 2005
	Агуулахын байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт) галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих / Галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулгын самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл., /	Объектын доторх ашигтай талбайгаас хамаарч 80м ² ихгүй талбайд тус бүр 1ш галын хор 40.0 байршуулах Эхний байдлаар 3-5 ш хор	10.0 хор + 5 иж бүрдэл	0.5	Жилд нэг удаа	

³ Үйл ажиллагааны задлаар санхүүжүүлнэ.

⁴ Төслийн талбайд ойр орших

⁵ Ашиглалтын хугацаанд хийгдэх дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

Байгууламжийн барилгын ажлыг бүрэн хүлээлцсэний дараа галын аюулгүй байдлын дүгнэлт, гэрчилгээг холбогдох мэргэжлийн албаар гаргуулж тухайн дүгнэлтийн дагуу гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх	Галын дүгнэлт, зөвшөөрөл	200.0	200.0	Үйл ажиллагааны эхний жилд	Галын аюулгүй байдлын тухай хууль
Шаардлагатай тохиолдолд галын эсрэг төхөөрөмж нэмэлтээр суурилуулж, галын хорын тоог нэмэгдүүлэх, гэнэтийн осол аюулын үед ашиглах хамгаалах хэрэгслийг (амьсгалын баг гэх мэт) байршуулах		Гүйцэтгэлээр төсөвлөнө.			Гамшгаас хамгаалах тухай хууль
Ажилчдын тосгон, гал тогоонд галаас сэргийлэх арга хэмжээ, заавар зөвлөмжийг байнга өгч байх				Байнга	
ТМА-ын үйл ажиллагааны явцад галын аюул, гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Жишиг тариф 1800.0 Гэрээгээр тохиролцсон төсвөөр			Гамшгаас хамгаалах тухай хууль
Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж өөрийн ОБХТ-д (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	200.0		Ашиглалтын хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Зохион байгуулах	150.0*4=600.0		2023 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах		150.0*4=600.0			
Аюултай болон хортой бодис, материалыг хадгалалт, ашиглалтын үед аюулгүй ажиллагааны болон осол аваарын үед авах арга хэмжээний дарааллыг тогтоож, түүнийг мөрдөж ажиллах		-			Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
Нийт		3400.0			

IV.4 Тэр бум мод үндэсний хөтөлбөр

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаарт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” хөтөлбөрийг тусгав.

Хүснэгт№ 19 Ойжуулалтын зардал

№	Зардлын утга	Нэгж	Талбайн хэмжээ	Тоо, ш	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Навчит модны суулгацаар ойжуулах	га	0,5	500	10 900 000	13 100 000
2	Навчит модны суулгацаар ойжуулсан талбайн арчилгаа				2 200 000	

IV.5 Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн төсөл хэрэгжих явцад газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

IV.6 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн орд төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

IV.7 Хатуу хог хаягдлын менежмент

“Хас металл” ХХК нь ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ялган төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн хаяна.

- Техникийн хувьд бүрэн бус, гэмтэлтэй тээврийн хэрэгслийг цаг тухайд нь засвар, үйлчилгээнд оруулж байх, хэрэв хөрс шатах, тослох материалаар бохирдсон бол тухай бүрд нь зохих стандартын дагуу ариутгаж, цэвэрлэх,
- Уурхайд ашиглагддаг түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүнийг зөөх, тээвэрлэх, хадгалах, ашиглах журам зааврын талаар сургалт явуулах, гарын авлагыг бодис тус бүр дээр бэлтгэн тараах, санамж сэрэмжлүүлэг бүхий мэдээллийн самбарыг шаардлагатай газруудад байрлуулах, дотоод дэг журмыг нарийн чанд мөрдүүлэх
- Хатуу хог хаягдлыг хадгалах цэг байгуулан түүнд төвлөрүүлэн хаяж байх, Хатуу хог хаягдлын цэг нь зориулалтын тагтай, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой. Хураагдсан хог хаягдлыг тодорхой давтамжтайгаар төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэн хаяж байх.
- Хатуу хог хаягдлыг зориулалтын сав, баглаа, боодолд хийж тусгай цэгт хаяна
- Хог хаягдлыг ангилан ялгалт хийж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ялгах
- Хог хаягдлаас үүсч болох элдэв төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх
- Ахуйн хэрэгцээнээс гарах бохир шингэнийг аюулгүй горимын дагуу тээвэрлэж, хадгалах
- Шингэн хаягдлыг уурхайн ажилчдын эрүүл мэндэд хор нөлөө учруулахгүйгээр хол зайд байрлуулах
- Хөрсөнд нэвчихгүй байх арга хэмжээг авах

Хүснэгт№ 20 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөө

д/д	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Зарцуулагдах зардал мян.төг	Шалгуур үзүүлэлт
			2023 он	
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ Даланжаргалан сумын засаг даргаар тогтоолгоно.	Компанийн захирал	-	Даланжаргалан сумын засаг даргын захирамж байна.
2	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Гэрээ байна.
3	Хог хаягдлын төлбөрөө төлнө.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Төлбөр төлсөн баримт байна.

4	Хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож Даланжаргалан суманд сар тутамд мэдээллэж байна.	Уурхайн дарга	-	Уурхайд 47 хүн ажиллах бөгөөд сард ойролцоогоор 9.2 кг хатуу хаягдал гарна.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг Багахангай дүүрэгт байрлах “Алтан-Оршихуй” ХХК-ийн хаягдал тос масло боловсруулах үйлдвэрт тээвэрлэн хүргэнэ.		Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон	Хог хаягдлын журнал хөтлөж явна.
6	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ. Бага оврын цэвэрлэх байгууламж суурлуулна.		-	Хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал нь тусгагдсан.
7	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх		350.0	Дорноговь аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэх
8	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал		450.0	Жил бүр
Нийт зардал мян.төг			800.0	

IV.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт Өлзийт-ухаагийн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж хэмжих, шинжлэх арга стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх болон үр дүнг хянах ажлыг “Хас металл” ХХК-ийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдана.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11 сард багтааж сум, аймгийн төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулах хэрэгтэй.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон түүний хэрэгжилтийг хянах субъектүүд ажил, үүрэг: Байгаль орчны мэргэжилтэн дараах ажлыг гардан зохион байгуулна.

- Төсөл хэрэгжүүлэгчийн жилийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэгчтэй холбогдсон зардлыг тусган батлуулсан байх,
- Төслийн талбайн ойр орчмын цэгүүдээс дээжийг тогтоосон хугацаанд нь мэргэжлийн байгууллагуудаар авуулж, лабораторийн шинжилгээ хийлгүүлэх,

- Орчны хяналт шинжилгээний ажлыг байгаль орчны шинжилгээний төв лаборатори зэрэг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн гүйцэтгэх ба түүнд зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах,
- Шинжилгээний үр дүнг суурь үзүүлэлттэй жишин үзэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай, шийдвэрийн төсөл боловсруулах
- ИТХ, түүний тэргүүлэгчдэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнуулах, шаардлагатай шийдвэр гаргуулах арга хэмжээ авуулж, гүйцэтгэлийг хянах

Төсөл хэрэгжүүлэгч дараах асуудлыг хариуцна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг жил бүрийн төсөвт тусган саадгүй төлөх,
- Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулж тухайн орон нутгийн Иргэдийн нийтийн Хурал, түүний тэргүүлэгчдийн гаргасан шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хяналт шинжилгээний үр дүнг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн гаргаж, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын “Элдэв” багийн иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчид ба БОАЖЯ-нд тайлагнаж байх,
- Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгтийн загварыг Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газар болон хяналт шинжилгээ хийсэн мэргэжлийн байгууллагаас авах.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчид дараах асуудлыг хариуцна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, эрчимжүүлж, заавал хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд нөлөөлж буй асуудлаар иргэдийн санал хүсэлтийг авч судалгаа явуулах,
- Шаардлагатай асуудлаар зөв шийдвэр гаргах, арга хэмжээ авах

Хүснэгт№ 21 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин					
Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО ₃ , хүчил НСО ₃ , кальци Са, хлор Сl, кали К, магни Мg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор В, бари Ва, кадми Сd, кобальт Со, хром Сг, зэс Сu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Мп, молибден Мо, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактерилогийн бүрэн шинжилгээ.	-Унд ахуйн хэрэглээнд ашиглах худагт	Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Усны ерөнхий химийн шинжилгээ 30.0 мян.төг, Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 40.0 мян.төг, Хими бактерилогийн бүрэн шинжилгээний үнэ 70.0 мян.төг 1 жилд 2 удаа буюу нийт 140.0 мян.төг	70.0*2*1жил= 140.0мян.төг	-MNS 0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ -Усны чанар хаягдал бохир ус MNS 4943:2000
Хөрсний төлөв байдал, бохирдолт					
Нефть, нефтийн бүтээгдэхүүн, Хар тугалга, Азот, Фосфор, Усан мандал, Кальци, Магни, Кали, Магни, Хлор, Сульфат, Карбонат, Ариун Гидрокарбонат, Ариун цэврийн тоо, Коли- титр, Перфрингес-титр	Мониторингийн цэгүүдээс N 46° 1' 58,9" E 108° 48' 31,8" N 46° 1' 31,29" E 108° 49' 57,2"	Жилд 2 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 30.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 40.0 мян.төг 1 жилд 140.0	70 *2*1 жилд = 140мян.төг	-MNS 5850:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар					
-Тоосжилт (PM ₁₀ , PSM, PM ₂₅)	- Мониторингийн цэгүүдээс:	Жил бүр 2 удаа.	24 цагийн хэмжилт хийж (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO , цаг	250.0 төг*2*1 жилд 500.0 мян.төг	-ISO 9001:2000 MNS0017.2.5.12:88 Хүхэрлэг хий-SO ₂

<p>- Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын давхар исэл, Аммиак г.м</p>	<p>108°49'7.49" 46°1'35.0" 108°49'21.79" 46°2'21.79"</p>		<p>Шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь.</p>	<p>агаарын үзүүлэлт)-ийи хамт тооцоход 250.0 мян.төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов. 1 жилд 500.0</p>		<p>шинжлэх ТХМ буюу аэрозалины арга -MNS0017.2.5.11-88 Азотын давхар исэл</p>
Ургамал						
<p>-Хяналт шинжилгээ хийх талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлно.</p>	<p>Мониторингийн цэгүүдээс: 108°49'12,54" 46°1'57,28" 108°49'42,77" 46°1'16,13"</p>		<p>жилд 1 удаа</p>	<p>Мэргэжлийн шинжээч хөлслөх, 800.0 мян. төг</p>	<p>800 *1 жил = 800.0 мян.төг</p>	<p>-Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох</p>
Нийт дүн				1580.0 мян.төг	1580.0 мян.төг	

IV.9 Байгалийн гамшгаас үүсэж болзошгүй ослын менежментийн төлөвлөгөө

Газар хөдлөлт: Төсөл хэрэгжих район нь 6 баллын газар хөдлөлийн бүсэд багтдаг. Газар хөдлөл нь байгалийн гамшгийн хамгийн аюултай хэлбэрийн нэг бөгөөд газар хөдлөлийг урьдчилан тогтоож, мэдээлэх боломж муу. 2023 онд баригдах уурхайн барилга байгууламж, тоног төхөөрөмж, газар доорх шугам сүлжээг барьж байгуулах, суурилуулахдаа газар хөдлөлийн хэдэн балл хүртэл тэсвэрлэх чадвартай болон уг үйлдвэрлэлд тохирох эсэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагын үнэлгээ гаргуулна.

Салхи, шуурга: Хавар, намрын улиралд, ялангуяа хаврын улиралд үе үе хүчтэй салхитай байдаг бөгөөд салхины хамгийн их хурд 28 м/сек-ээс хэтрэх тохиолдол тус бүс нутагт олонтоо тохиолддог. Хавар, намрын саруудад салхины хурд хамгийн их байдаг.

Салхи шуурганы хүчтэй нөлөөлөл үүсэх нөхцөлтэй тул бүтээгдэхүүнийг тээвэрлэх, шатах тослох материалын агуулахыг байршуулах, үйлдвэрлэл явуулахдаа тогтмол цаг уурын мэдээ сонсож дээрх нөлөөллийг сайтар харгалзан үйл ажиллагааг явуулна.

Үер: Уурхайн район нь олон жилд цөөн удаа тохиолдох үерийн аюулд бага өртөнө. Зуны хур борооны үед цаг агаарын нөхцөлөөс хамааран үерийн аюул ажиглагдах нөхцөлтэй тул уурхайд үерийн ус зайлуулах далан байгуулна.

Аянга цахилгаан: Зуны улиралд, ялангуяа хур бороо элбэгтэй 7, 8 дугаар саруудад аянга цахилгааны үзэгдэл илүүтэй тохиолдоно. Зуны улиралд 20 орчим өдөр аянга цахилгаан буудаг, 1.0 км² талбайд 4-6 удаа ниргэлт болдог нь үйлдвэрийн болон уурхайн техник хэрэгсэл, хүмүүсийн үйл ажиллагаа хөдөлмөрийн нөхцөлд түр саатал бэрхшээл учруулж, улмаар аюул осол тохиолдож болох магадлалтай.

V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана.

“Хас металл” ХХК-ийн байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Компаний удирдлага
2. ХАБЭА-н инженер

Эдгээр 2 хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайланг орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, болон нутгийн иргэд, ТББ хянаж оролцож байхаар тусгав. Зардлыг тухайн үеийн төлөвлөгөөт зардлаар тооцно.

Хүснэгт№ 22 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал

№	Арга хэмжээ	Хугацаа	Давтамж
II-1	Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).	2023	Байнгын
II-2	Байгаль орчны бодлого, зорилго, зорилт, хууль эрхзүйн болон бусад шаардлагуудын дагуу үйл явцыг хянаж хэмжих ба үр дүнг тайлагнах	2023	Жил бүр
II-3	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр
II-4	Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компаний хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;	2023	Жил бүр
II-5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн явцын талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тайлагнах.	2023	Жил бүр
II-6	Төслөөс үүсч болзошгүй нөлөөллийг хамгийн бага байлгах буюу нөлөөлөлгүй байлгах үүднээс соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;	2023	-
II-7	Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг оролцогч талууд болон орон нутгийн удирдлагуудад мэдээлж байх;	2023	Жил бүр
II-8	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдолыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2023	-
II-9	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах, тэдний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг гэрээнд тусгах	2023	Тухай бүрт нь

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь:

“Хас металл” ХХК нь “Өлзийт-ухаа” төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй мэдээлэл оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмыг мөрдлөг болгон ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах үүргээ хэрэгжүүлэх зорилготой дараах арга хэмжээг төлөвлөсөн.

Хүснэгт№ 23 БОМТ-г тайлагнах хуваарь

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2023.07.21	Уурхайн үйл ажиллагаатай сум, багийн нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн газар дээр нь танилцуулах	20-30 хүний суудалтай бага оврын автобус хөлсөлнө. Автобусны 1 өдрийн хөлс 110 000 төг. 1 хүний өдрийн хоол 6000 төг. 30*6000=180000төг 110000+180000=290000	Уурхайн дарга болон компанийн захирал
2023.11.01	Дорноговь аймгийн засаг дарга, ИНХ-ийн төлөөлөгчид, Даланжаргалан сумын ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдэд танилцуулж санал авах	ЗДТГ-ийн хурлын танхимд төлөвлөгөөг танилцуулна. Тараах материал, зарлалын самбарын зардалд 100000төг. Танилцуулгад хүрэлцэн ирсэн иргэдэд өдрийн цайнд 80000 төг төсөвлөлөө. 80000+100000=180000төг	Уурхайн дарга болон компанийн захирал
	Нийт зардал	Төг 470 000.0	